

Тиан И Пэнг

Жилиний Их Сургууль. Философи, Социологийн сургуулийн дэд захирал

Социологийн тэнхмийн эрхлэгч

Жилиний Их Сургууль. Багшлах төвийн тэргүүн

Хятад Улсын Социологийн шинжлэх ухааны хяналтын зөвлөлийн жинхэнэ гишүүн

Боловсролын яамны дэргэдэх Социологийн шинжлэх ухааны удирдах зөвлөлийн гишүүн

Жилин мужийн Бодлого зохицуулалтын хорооны зөвлөх гишүүн

доктор, профессор

С.Нарантуяа *(Хятад хэлнээс хөрвүүлсэн)*

МУИС.НШУС. Социологи-Нийгмийн ажлын тэнхмийн багш

УЛАМЖЛАЛТ МЭДЛЭГИЙН ШИНЭЧЛЭЛ БА ХЯТАДЫН СОЦИОЛОГИ

Abstract: *It could be said currently that Chinese sociology is implementing successful its reform. Although, if to take higher criteria, Chinese sociology has succeeded in its reform it has not reached a reform in science. Therefore, we focus on further development of Chinese sociology and knowledge in modern times.*

Key words: *traditional knowledge, reform of knowledge, change, China, sociology, import.*

Хэрвээ Хятадын социологийн хөгжлийн үндэс суурийг 1979 оноос тавигдсан гэж үзвэл нэгэнт ардаа 30 гаруй жилийг үджээ. Энэ өнгөрсөн хугацаанд Хятадын социологи нь өөрийн гэсэн шинж төрх бүхий судалгаатай болсон. Өнөөдрийн байдлаар Хятадын социологи шинэчлэлийн ажил аль хэдийн эхний алхмаа амжилттай гүйцэтгэсэн гэж хэлж болно. Гэхдээ бид илүү өндөр шалгуураар авч үзвэл, Хятадын социологи шинэчлэлийн үе шатаа амжилттай давсан хэдий ч жинхэнэ төгс утгаараа шинжлэх ухааны шинэчлэлд хараахан хүрч чадаагүй байна, гэхдээ энэ хоёрын хооронд багахан зай үлдээд байна. Яагаад гэвэл, мэдлэгийн шинэчлэл нь одоо л зохицуулагдах үедээ явж байна. Шинэчлэлийн эн тэргүүний ойлголт буюу бодит зүйл болсон сургалт, түүний зохион байгуулалт зэрэг нь мөн биелэлийнхээ шатанд ороод байна. Үүнээс гадна уламжлалт мэдлэгийн шинэчлэл нь Хятадын социологийн сэргэн мандлын гол зангилаа асуудал болоод байгаа юм.

Бидний мэддэгээр, Хятадын уламжлалт үзэл сурталд хэдийгээр социологийн арвин үзэл санаа багтдаг хэдий ч орчин үеийн шинжлэх ухаанд тулгуурласан социологийн системлэг онол байдаггүй. Хятадын мэдлэгийн ертөнцөөс авч үзвэл, Социологи судлал нь нэг талаас гадны бүтээгдэхүүн, өөрөөр хэлбэл, импортоор орж ирж байгаа бараа, нөгөө талаас социологи нь баруунаас дундад руу орж ирж байгаа мэдлэгийн зогсолтгүй урсгал төдийгүй бас дундадынхны хувьд буцалтгүй зам юм. Хятадын социологийн онолын ойлголт, хүрээ, ухагдахуун, үзэл баримтлалын систем ба судалгааны аргууд нь бүгд барууны арга барилд хөтлөгдсөн, тодруулж хэлбэл дундадын социологи бол баруунаас орж ирсэн “импортын бараа” юм. Тиймдээ ч социологийг “Импортын бүтээгдэхүүн” гэж нэрлэсэн, тиймдээ ч Хятадын социологийн шинжлэх ухаан яалт ч үгүй барууныхтай салшгүй холбоотой. Ийнхүү Хятадын социологид баруунжих өнгө төрх байнга хүч түрэн орж ирж байгаа нь хятадын социологийн шинжлэх ухаанд асар том өөрчлөлт орж байгааг харуулж байна.

1937 онд Хятадын социологич Янг Кай Дао “Хятадын феодалын нийгэм” нийтлэлийн оршил хэсэгтээ ийнхүү бичжээ: “АНУ-ын социологийн шинжлэх ухааны дутагдалтай тал бол тэд гадаадын нөхцөл байдлын талаар бичихийн оронд, зөвхөн өөрийн орны талаар бичдэг, харин хятадын социологийн шинжлэх ухааны дутагдалтай тал бол яг эсэргээрээ буюу тэд өөрийн орны талаар бичихийн оронд, тэд зөвхөн гадаадын орны нөхцөл байдлын талаар бичдэг. Ялангуяа социологи гэдэг энэ талбарт судалгаа явуулж буй НӨХӨД-ийн тал гаруй хувь нь америкжсан, америкийн “хоолыг идсэн”, америкийн нийгмийн зарим нэг салбарыг судалсны

хувьд тэр НӨХӨД-өөс америкийн хүчтэй өнгө, үнэр ялгарч байдаг учраас НӨХӨД-ийн сонголт бол Америк, харин Хятад биш байлаа. Энэ НӨХӨД хятадын нийгмийн бодлогын хангалтгүй /хоосон/ орон зайгаар тэнүүчлэн явж, тэдний Хятадын социологийн хөгжлийг хойш татах хүсэл нь, үгүйсгэх хүсэл нь “бадарч” байгаа. Ийм маягийн зөвхөн барууны үзэл баримтлалыг дагасан социологи нь өөрийн эрхгүй хятадын мэдлэгийн ертөнц хангалтгүй, хятад нийгэм судлал мөхөс гэдгийг илтгэж байна” гэжээ.

Гэвч хятадын социологийн шинжлэх ухааны гол зорилго нь “Хятадын социологи”-ийг бүтээх биш, харин социологийн үзэл санаа үндсэн ойлголтуудыг гүн ойлгож мэдэх, онолын судалгаа хийх, системтэй туршилт судалгааг дэлгэрүүлэх, дэлхийн социологийн хөгжилд хувь нэмэр оруулах явдал юм. Энэ ч утгаараа хятадын социологи “нийгмийн шинжлэх ухааны бүс биш”, харин ч эсрэгээрээ хятад эрдэмтдийнхээ нөр их хөдөлмөрийн дүнд бид дэлхийн нийгмийн шинжлэх ухааны системийг оруулж ирж чадсан. (Еэ Чи Жэнг: “Хятадын социологийн хэв маяг, социологи судлалын чиглэл ба асуудал”, “Гадны социологи” 1993.3-4) Уг бүтээлд барууны социологийн онол, нийгмийн үзэл санаа, туршлага, судалгаа тусгагдсан бөгөөд энэ нь социологийн уламжлалт мэдлэг шинэчлэлийн гол цөм ярианы сэдэв болоод байна.

Социологийн уламжлалт мэдлэг шинэчлэлийн үйл явц нь маш төвөгтэй, шинээр ойлголт, ухагдахуун гаргаж ирэх шаардлагатайн дээр дундад судлал, баруун судлал хоёр нь хоорондоо тэгш эрхтэй оролцож байж сая хийж гүйцэтгэнэ. Энд дурьдсан “ойлголт ухагдахуун гаргаж ирэх” гэдэг ойлголт нь барууны онол арга барилыг тэр чигээр нь орчуулж оруулж ирэх, дан өөрийн дотоодын арга барилыг тусгах хоёрын аль аль нь бишийн зэрэгцээ мөн урьдын уламжлалт сэтгэлгээндээ баригдах бус, харин “холимог” сэтгэлгээгээр дундад, барууныг хослуулан аливаа асуудалд дүн шинжилгээ хийх нь нэгэн төрлийн шинэ гарц, үүд юм.

Гэхдээ бид дотоодын нийгмийн уламжлалт судалгаа шинжилгээ, баялгийг ухан гаргаж ирэх хэрэгтэй. Үүний тулд эрдэмтэн Ханг Ниу Чонг Донгийн уламжлалт сонгодог онол дотроос хятадын нийгмийн материалыг хайхад анхаарвал зохино. Цаг хугацааны байдлаас харах юм бол социологи судлал нь хэдийгээр нэгэн төрлийн орчин үеийн судалгаа шинжилгээ ч гэлээ, жинхэнэ мөн чанар нь хүн төрөлхтөн, нийгмийн өөрчлөлтийг улам илүү далайцтай тайлбарлах хүч, онол болж байдаг чухал хүчин зүйл юм. Мөн энэ тайлбаргаа эртний соёлоо хослуулан хэрэглэх нь зүйтэй юм.

Хэдийгээр социологи судлал нь “шилжилт” болон “өөрчлөлт”-ийг анхааран судалдаг боловч, нийгмийн өөрчлөлтийн хамт “үргэлжлэл” гэдэг зүйл ч бас давхар агуулагдаж байдгийг мартаж болохгүй.

Улс орон, үндэстэн ястангууд өөрсдийн гэсэн зуу, мянган жилийн урт удаан хугацааны түүхтэйгээр барахгүй тэр нь зогсолтгүй ахиж хөгжиж байдаг нь улс, үндэстэн бүрт заавал өөрийн оршин тогтнох асар их хүч хадгалаастай байдгийг харуулдаг. (“Хятадын түүх судлалын хууль” 2001.35) Үүнээс үүдэн соёлт нийгэм өөрөө урт удаан хугацааны хөгжлийн турш хураасан “нөөц бололцоо” гэсэн “хөдлөшгүй” хүчин зүйлтэй. Энэ нь өөрөө судалгааны хамгийн зохистой “арга барил” нь болох ёстой. Дэлхий дээрх бусад соёлтой харьцуулбал хятадын соёлын хамгийн том онцлог бол “эрт боловсрох” ба хөгжлийн чиг хандлагыг “үргэлжлүүлэх” гэсэн ойлголтыг бий болгох юм.

Эрт үед Күнзийн үзэл суртлыг гол болгон авч үзэж байсан ба түүний “онцгой” нийгмийн үзэл суртал, систем нь хятадын нийгэм бусад үндэстнээс ялгаатай болохыг тогтоосон. Тиймээс дахин боловсруулагдаж буй хятадын социологи судлалын хувьд “дотоод асуудал” гэдэг зүйл дээр тайлбар гарч ирэхийг санах хэрэгтэй бөгөөд хятадын нийгмийн үзэл суртал, судалгаа гэдэг салбарыг заавал нөхөн оруулж өгөх хэрэгтэй.

Түүнээс гадна социологийн талаар авч яривал, зөвхөн хятадын нийгмийн сонгодог үеийг судлах нь мөхөс ба мөн орчин үеийн амьдралыг авч үзэх шаардлагатай. Тэрбумаар тоологддог хятадын ард түмний амьдрал, үнэ цэнийн судалгаа явуулахад барууны социологийн шинжлэх ухааныг тэр чигээр нь загварлан авахад багадаа ба энэ улс өөрсдөө шинэ ойлголт, ухагдахууныг хичээнгүйлэн гаргаж ирэх цаг болсон. Нөгөө талаас гадны социологийн онолуудыг эргэцүүлэн бодож дүн шинжилгээ хийх хэрэгтэй. Онолыг өөрсдөдөө шууд хуулбарлан авч хэрэгжүүлэх нь амаргүй зүйл бөгөөд аливаа онолын цаана соёл, түүхийн үүсэл дээр тулгуурласан бодит амьдралын үйл явц агуулагдаж байдаг.

Мэдээж, Хятад гэдэг энэ соёлт орны тухай авч үзвэл, нилээн төвөгтэй зангилаа асуудал нь “хятад судлал” ба “баруун судлал” хоорондын харилцааны асуудлыг шийдэх явдал юм.

Хэдийгээр хятадуудын хувьд баруунд суралцан, энэ нийгэмд “дасах”, эрдэм шинжилгээ, судалгааны тойргийн хувьд хамгийн хол хязгаар нь байсан ч баруун судлал хүчтэй орж ирэн орчин үеийн нийгмийн шинжлэх ухааны системийг бий болгожээ. Гэвч барууны шинжлэх ухааны хүрээ нь хүмүүст мэдлэг олгох зорилго дээр тулгуурлан үүссэн байдаг бол харин Күнзийн “сурталтан”-уудын судалгаа шинжилгээ нь “зан суртахууны өсөлт” ба “хүн төрөлхтний эцсийн халамж сайн сайхан байдал? “ гэх мэт хэрэгцээт хүслээс бий болсон байдаг. Эхнийх нь буюу барууныхны логик бол “мэдлэг”, сүүлийнх нь буюу Күнзийнхний логик бол “хийх” юм. (Фан Чао Жүнь “Хятад-Баруун судлал” Тиан Жиний нийгмийн шинжлэх ухааны факультет 2002 он) Энэ логик нь “Хятад, баруунд суралцан дасах” судалгаа шинжилгээний аян замд зөрчилдөөн, бэрхшээл тулгарч байгааг илэрхийлнэ.

Түүнчлэн дүрэм журамгүй, эмх цэгцгүй социологиос болж, тухайн шинжлэх ухааны орон зай хоосон дутмаг болж, тэр орон зайд гаднаас “импортын бараа” орж ирсэн. Гэвч “импортын бараа” тэр газрынхаа хөрсөнд уусан шингэж чаддаггүй. Энэ байдал бол аль ч шинжлэх ухааны хувьд “өөрийнхөөрөө бодохуй” хэмээх, судлаач хүнд заавал тулгардаг үнэн бодит асуудал юм.

БНХАУ. Чангчун хот

2011 он 9 дүгээр сар.